



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/24

Амардалай

┌ Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ┐  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.9 Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7 дахь заалтууд, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны А/115 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.2023-2024 оны өвөлжилт хаваржилт хүндэрсний улмаас хорогдсон малын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд: Б.Баттогтох (ХААТ-ийн дарга)

Б.Сармандах (ХААТ-ийн мэргэжилтэн)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

А.Алтансүх (ЗДТГ-ын ажилтан)

Б.Дэлгэрсайхан (ЗДТГ-ын жолооч)

М.Даваацэрэн (МЭҮН-ийн малын эмч)

М.Ганьхүү (МЭҮН-ийн эмч)

2.Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж булж устгах, халдваргүйтгэлийн ажлын төлөвлөгөөг 2-р хавсралтаар баталсугай.

3.Байгаль цаг агаарын хүндрэлээс болж зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг халдварт өвчин тархах, байгаль орчны бохирдуулахаас сэргийлж уст цэг, төв авто зам дагуух, төв суурийн газраас цуглуулж, нэгдсэн усгалын "Хөх овооны"

102401041

цэгт булж устгах, халдваргүйтгэх арга хэмжээг 03 сарын 10 нээс эхлэн 06 сарын 01-ний хүртэл хугацаанд шуурхай зохион байгуулж, дүн мэдээг долоо хоног бүрийг 3 дах өдөр Мал эмнэлгийн газарт мэдээлж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг )-т даалгасугай.

4.Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, байгаль орчныг цэвэрлэх халдваргүйтгэлийн ажиллагааг чанартай үр дүнтэй зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (С.Нарантунгалаг )-т тус тус үүрэг болгосугай.

5.Устгалын ажилд шаардлагатай зардлыг Засаг даргын нөөц, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулахыг ЗДТГ-ын дарга (С.Нарантунгалаг), нягтлан бодогч ( Г.Дэжидсүрэн )-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ.

